



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2011 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 762

Улаанбаатар хот

Г Журамд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2010 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 460 дугаар тушаалаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 2.6.1 дэх заалтыг дор дурдснаар өөрчлөн найруулсугай:

“2.6.1. Банк болон банк бус санхүүгийн байгууллагын өөрийн хөрөнгөд шууд болон гуравдагч этгээдээр дамжуулан байршуулсан хөрөнгийн 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс тус тус хасна.” гэж.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 726 дугаар тушаалын 3.а дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Лхагвасүрэн/-т даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ



Л.ПҮРЭВДОРЖ